



“Эрдмин” ХХК-ийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

Тайлангийн агуулга:

1. “Эрдмин” ХХК-ийн Катодын зэс боловсруулах үйлдвэр, Зэс утасны үйлдвэрийн товч танилцуулга
2. Эрдмин үйлдвэрийн 2025 оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга
3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, Орчны хяналт шинжилгээ
4. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ
5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ
6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ
7. Осол, эрсдэлийн менежмент
8. Хог, хаягдлын менежмент
9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ
10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах
11. Дүгнэлт
12. Хавсралтууд
 - Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөлүүд
 - Химийн бодисын агуулахын дүгнэлт
 - Галын аюулгүй байдлын дүгнэлт
 - Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөлүүд
 - Орчны хяналт шинжилгээний дүнгүүд
 - Химийн бодисын ашиглалтын дүн мэдээ
 - Аюултай хог хаягдал шилжүүлсэн акт, аюултай хог хаягдлын бүртгэл



НЭГ. “ЭРДМИН” ХХК-ИЙН КАТОДЫН ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БОЛОН ЗЭС УТАСНЫ ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Эрдмин” ХХК нь Монгол Улсын 9019007004 тоот аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй, 2073358 бүртгэлийн дугаартай, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн 517 тоот гэрчилгээтэй компани бөгөөд “Эрдэнэтийн овоо орд”-ын гадаад овоолгод тавигдсан /Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын технологид таардаггүй/ исэлдсэн болон холимог хүдрийн овоолгыг өөрийн далангуудад шилжүүлэн тавьж тэдгээрийг шүлтгүйжүүлэлт-хандлалт/ электролизийн (Leaching-SX/EW) технологиор боловсруулж жилд 3000 тонн 99,999 сорьц бүхий катодын зэс үйлдвэрлэх хүчин чадалтайгаар 1997 оны 01-р сарын 17-нд ашиглалтанд орсон.



“Эрдмин” ХХК нь гидрометаллургийн “L-SX-EW” буюу Уусгалт-Уусган хандлалт-Цахилгаан химийн технологи ашиглан “Уулын Баяжуулах Эрдэнэт Үйлдвэр” /хуучин нэрээр/ -ийн исэлдсэн болон холимог хүдрийн овоолгоос хүхрийн хүчлийн сулруулсан уусмалыг ашиглан катодын цэвэр зэс үйлдвэрлэх зорилгоор байгуулагдсан байна. Тус компанийн үйлдвэрлэж буй катодын зэсийн чанарыг олон улсад нэр хүнд бүхий Английн “Alex Stewart Assayers” компани баталгаажуулдаг ба катодын зэсийн чанар +99.999%-ийн цэвэршилттэй байгаа нь Лондонгийн металлын бирж дээрх “А” зэрэглэлийн чанарын шаардлагыг хангаж байна.



2005 онд өөрийн үйлдвэрлэсэн катодын цэвэр зэсээс 2000тн-ийг хайлуулж, цувин 8 мм-ийн голчтой зэс татанги үйлдвэрлэж, түүнийг дахин боловсруулж кабель утас үйлдвэрлэн нэмүү өртөг шингээн борлуулах Монгол Улсын анхны Зэс утасны үйлдвэрийг ашиглалтад оруулсан.



Зэс утасны үйлдвэр нь одоогоор ил болон далд цахилгаан монтажны 50 гаруй нэр төрлийн цахилгаан монжатны кабель утас үйлдвэрлэхээс гадна цахилгааны өндөр хүчдэлийн газардуулга, щитэнд ашиглах зэс тууз /шинн/ 5 төрлөөр үйлдвэрлэж байна.



ХОЁР. ЭРДМИН ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эрдмин үйлдвэр нь 17,2 сая тонн хүдрийн нөөц бүхий 4 овоолго дээр 28 жилийн турш тасралтгүй ажиллаж байна. Манай овоолгууд дахь зэсийн агууламж анх 0,72% зэс агуулж байсан бол өнөөдрийн байдлаар 0,29% болж буурсан үзүүлэлттэй байна.

Хүдрийн нөөцийг ашиглалтын төрлөөр ангилбал:

1. Нийт хүдрийн нөөц - 17,289 сая тонн
2. Байршлын хувьд ашиглах боломжгүй (зөөж, ашиглах) - 3,009 сая тонн
3. Ашиглалтаас хасагдах "А" (1-р овоолго 1996-2018 онд ашиглаж дууссан) – 3.2 сая тн
4. Ашиглалтаас хасагдах "Б" (2,3,4- р овоолгоос уусгаж дууссан) – 1,186 сая тонн
5. Ашиглаж байгаа нөөц – 9,894 сая тонн 0,29% зэс агуулсан хүдрийн нөөц байна.

1,2-р овоолгуудын хувьд уусгаж авах боломжтой металлынхаа 70-78 орчим хувийг авсан бөгөөд цаашид дангаар нь ашиглах боломж байхгүй юм. Өөрөөр хэлбэл уусгалтын овоолгуудаас SX-ийн хэсгийг шаардлагатай зэсийн агуулга бүхий (1,6 г/л-ээс дээш) шимт уусмалаар хангах боломжгүй юм. Иймд тухайн овоолгуудын дээр байршлын хувьд уусгаж ашиглах боломгүй байгаа 2А овоолгоос хүдэр зөөн байрлуулж хамтран уусгаж түүхийн эдийн нөөцөө бүрдүүлж байна.

Харин 3, 4-р овоолгуудын хувьд 3-10 жил ашиглагдсан, зэсийн агуулга харьцангуй ядуурч байгаа уусгалтын овоолгууд юм.

2021 оноос SX-ийн хэсэгт Төмөр угаах шатыг тухайн нөхцөлд тохируулж тогтмол ажиллуулж байсан ба электролитруу нэвтрэх төмрийн хэмжээг 40-50% -р бууруулж байгаа нь зэсийн бага агуулга, төмрийн их агуулга бүхий уусмалаас үйлдвэрлэх зэсийн хэмжээг тогтвортой байлгаж байна.

Уусгалтын технологийн хувилбарууд:

1. 1, 2, 4 овоолгыг хамт уусгасан (1,2,3,10,11,12 сард)
2. 2, 4 ба 3 – р овоолгыг хамт уусгасан (4,9 - р сард)
3. 3 – р овоолгыг уусгасан (5, 6, 7, 8-р сард)

Овоолгуудын уусгалтын ерөнхий төлөвөөс харахад зэс үйлдвэрлэлийн 40 орчим хувийг 3 – р овоолгоос, 35 орчим хувийг 4 – р овоолгоос, 20 орчим хувийг 2 – р овоолгоос 5 хувийг 1 – р овоолгоос үйлдвэрлэсэн байна.

Одоогын байдлаар 2025 оны үйлвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт 95% орчим байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2025 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭ

Агаарын чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөө:

- Тээврийн хэрэгслүүдийн элэгдлийн улмаас ялгаруулах утааны хэмжээ стандартаас хэтэрч агаарын чанарт сөргөөр нөлөөлөх
- Уусган хандлалт, электролизийн үйл ажиллагаанаас химийн бодисын ууршилт үүсэх

Компанид нийт 17 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байдаг ба тэдгээрийг улсын техникийн үзлэгт хамруулсан. Ашиглалтын явцад тогтмол үзлэг шалгалт хийж техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, доголдол үүсэхээс сэргийлэн ажиллаж байна.



Орхон аймгийн стандартчлал хэмжилзүйн лаборатори, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ХАБЭАБО-ны итгэмжлэгдсэн лабораторитой гэрээ байгуулж цахилгаан химийн цехэд явагдаж байгаа урвалын дүнд үүсч болох химийн бодисын ууршилтыг сар бүр хэмжүүлэн хянаж байна.



Стандартчлал хэмжилзүйн лаборатор нь ХЛ-А-07 стандартаар агаараас дээж авагч FC-1A маркын багаж ашиглан сорьж цуглуулж дүгнэлт гаргаж байна.

Гадаргын ба газрын доорх усны нөөцөд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөө:

- Уусгалт, уусган хандлалт, электролизийн үйл ажиллагаанаас хүхрийн хүчлийн сулруулсан уусмал алдагдах гадаргын усанд нөлөөлөх
- Төслийн үйл ажиллагаанаас газрын доорх ус бохирдох



- Овоолгийн хэсгээс байгалийн ус буюу хур борооны хуримтлагдсан шүүрлийн ус Хангал голд урсан орох

Уусган хандлалт, цахилгаан химийн процессоос химийн бодис алдагдахаас сэргийлэн үйлдвэрийн эргэн тойронд, жалга сувгуудаар тогтмол хугацаанд ээлж хэсгийн ахлагч нар үзлэг хийж тэмдэглэл хөтлөн баримтжуулах журамтай. Тайлант хугацаанд ямар нэгэн зөрчилгүй ажиллалаа.



Уусмал хуримтлуулах цөөрмүүдэд хяналт тавьж ажиллах явцдаа үйлдвэрийн анхны цөөрөм болох 1-р цөөрөм (1995-онд ашиглалтад оруулсан)-ийн өндөр нягтралтай полиэтилен /HDPE / доторлогоог сольж гарч болзошгүй аливаа эрсдэл, цоорол зэргээс сэргийлэн ажиллав.



Төслийн үйл ажиллагаанаас газрын доорх ус бохирдох эрсдэлээс сэргийлэх үүднээс үйлдвэрийн бүсэд газрын доорх усны 7ш хяналтын цэгүүдээс сар бүр тогтмол дээж авч шинжлэн хянаж байна.



Газрын доорх усны дээгид шинжилгээ хийж хянах ажлыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газар болон өөрийн лабораторид гүйцэтгэн үр дүнг харьцуулан хянаж байна. Мөн сар бүрийн шинжилгээний үр дүн, мэдээг Орхон аймгийн Байгаль орчны газарт, байгаль орчны хяналтын байцаагчид тайлагнаж байна.



Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 6148:2010/-стандартыг баримтлан газрын доорх усанд рН, SO₄-г тодорхойлж байна.

Мөн технологийн уусмал хуримтлуулах цөөрмүүдийн доор хяналтын хоолойн төлөвлөсөн байдаг ба тогтмол хянаж ажиллаж байна.



Хур тунадас ихтэй жил үйлдвэрийн бүсрүү уусгалт явуулдаггүй овоолгуудаас борооны ус шүүрч ус гарсаар байна. /бид тухай бүр баримтжуулан холбогдох байгууллагад мэдэгдэж ажилладаг/



Дээрх шүүрлийн усыг 400м^3 -ийн багтаажтай хуримтлуулах хэсэгт цуглуулж "Эрдэнэт үйлдвэр"ТӨҮГ-ын 5000м^3 -ийн эзлэхүүнтэй цөөрөмрүү татан авч жалга судаг, цаашлаад Хангал голруу шүүрлийн ус орохоос сэргийлж ажиллав.

Хөрс болон ургамалд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах:

Мөн Эрдмин үйлдвэр нь хүдрийн овоолгын уланд хүчитгэсэн полиэтилин мембрамыг дэвсэж овоолго байгуулдаг тул технологийн уусмал хөрсөнд нэвчих эрсдэлийг тэр хэрээр бууруулж байна.



Мөн хөрсний бохирдлоос сэргийлж Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газартай хамтран улирал тутам 4 цэгээс дээж авч рН, SO_4 , чийг, PO_4 , NO_3 ялзмаг, NH_4 зэрэг 7-н үзүүлэлтээр хянаж ажиллаж байна.

ДӨРӨВ. НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Гэнэтийн нөхцөлд шаардлагатай эрсдэлийн сан үүсгэх
- Сум орон нутгийн хүсэлтээр эхийг сэргээн хашиж тохижуулсан булгийг үргэлжлүүлэн хамгаалах
- Эдэлбэр газрыг тогтмол ургамалжуулж газрын гадарга элэгдэхээс сэргийлэх

Гэнэтийн байдлаар байгаль орчинд хохирол учруулахуйц осол, аваарь гарсан үед ашиглах эрсдэлийн сан үүсгэхээр компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу тусгай дансанд жил бүр 5'000'000 /таван сая/ төгрөг хуримтлуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар дээрх мөнгөн эх үүсвэрийг ашиглахуйц ямар нэгэн зөрчил гараагүй тул тус сангийн мөнгөн хуримтлал болон хадгалагдаж байна.

Орхон аймгийн байгаль орчны газраас санал тавьсны дагуу Баян-Өндөр уулын урд бэлд байх Хүрэн булгийн рашааны ундрагыг нөхөн сэргээх чиглэлээр Эрдмин үйлдвэр жил бүр тодорхой ажил зохион байгуулдаг. Энэ ажлын хүрээнд 2017 онд анх булгийн эхийг металл хашаа барьж хамгаалан, орж гарах хэсгийн элэгдэж нурсан байсныг сэргээн засварлаж, бетон шат байрлуулсан.



2025 онд мөн Хүрэн булгийн рашаан орчмын хогыг цэвэрлэн, хамгаалалтын хашааг сэргээн засварласан байна.





Үйлдвэрийн бүсэд компанийн эдэлбэр газарт элэгдсэн, эвдэрсэн хэсгийг нөхөн сэргээх, ургамалжуулах ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байна.



Жил бүр үйлдвэр орчимд мод тарьж, ургамалжуулснаар 2025 оны байдлаар үйлдвэрийн барилга байгууламж барьсан талбай, хүдрийн овоолгийн талбай, авто замаас бусад хэсэгт эвдрэлд өртсөн газар байхгүй болсон байна.

ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

- 2024 оны хавар, намрын бүх нийтээрээ мод тарих өдрүүдээр орон нутгаас зааж өгсөн газарт мод бут сөөг тарьж арчлан ургуулж хамгаалах
- Өмнө жилүүдэд тарьсан моднуудын ургалт, хамгаалалтанд анхаарах, шаардлагатай тохиолдолд нөхөн тарилт хийх
- Эрдэнэтийн овооны ард тарьсан моднуудыг ойн санд хүлээлгэн өгөх
- Байгаль хамгаалах хавар, намрын сарын ажлын хүрээнд зохион байгуулах эзэнгүй дүүргийн хог хаягдлын цэвэрлэгээний ажилд БОАЖГ-ын зааж өгсөн талбайг цэвэрлэж нэгдсэн хогийн цэг рүү зайлуулах.
- 16000ш үрсэлгээ бойжуулах мод үржүүлгийн газар байгуулах

2025 онд Хангал голын гүүрний баруун урд талд (49° 4'24.84"N 104°11'19.55"E) 0,5га талбайд мод тарьсан ба услах, хамгаалалтын хашаа барих ажлыг зохион байгуулан ажиллалаа.





2018 оноос эхлэн 5 байршилд тарьсан 4410 ширхэг шинэс, улиас, чацаргана, хус, хайлаас зэрэг моднуудыг тогтмол услаж арчлан хамгаалж байна.



Дээрх моднууд 2025 оны намрын байдлаар 98%-ийн ургалттай, дундаж мод 1,8м-ийн өндөртэй байна.

Тайлант онд 1,28га талбайд хамгаалалтын төмөр торон хашаа барьж Орхон аймгийн Жаргалант сум орох зам дагуу, Согоот уулын ард Хангал голын голдирол дагуу (49° 4'38.35"N, 104° 14'46.68"E) 1,500 ширхэг бургас мод тарив.



"Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд "Эрдмин"ХХК 2,0 сая ширхэг мод тарих зорилт тавин ажиллаж байна.



Дээрх ажлын хүрээнд 2024 онд 20,000ш мод үржүүлэх хүчин чадал бүхий мод үржүүлгийн газар байгуулсан ба тайлант оны байдлаар шинэс, улиас, бургас, хуш, гүйлс, буйлс, агч зэрэг модыг үрээр болон мөчрөөр тариалан ургуулж байна.



2026 оноос эхний суулгацуудыг шилжүүлэн тариалах боломжтой болно.

Тайланд онд байгаль орчин аялал жуулчлалын ажлын хүрээнд эзэнгүй дүүргийн хог цэвэрлэх ажлыг зохион байгуулав. Энэхүү ажилд 45 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, Чингэлийн голын голдирол дагуу 5 м³ хог цэвэрлэн Орхон аймгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт хаяв.



Мөн 4-р сард үйлдвэр орчмын бүсэд цэвэрлэгээний ажил зохион байгуулж нийт 35га талбайд цэвэрлэгээ хийж, 13м3 хог хаягдалыг аймгийн хогийн төвлөрсөн цэгт хаясан байна.





ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Үйлдвэрийн хүдрийн овоолгийн талбайруу түрж ургасан зулзган моддыг шилжүүлэн суулгах

2025 онд үйлдвэрийн уусмал хуримтлуулах цөөрмүүдийн эргэн тойрон хавж, түрж ургасан 40 гаруй зулзган моднуудыг үйлдвэрийн бүс дотор, Мод үржүүлгийн газарт хашаалах зорилгоор шилжүүлэн тарьж ургуулж байна.



Жил бүр шилжүүлэн тарьсан моднууд үйлдвэрийн орчинд төгөл болон ургаад байна.

ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

- Химийн бодисын задгай талбайн эргэн тойрныг ургамалжуулах. Сав баглаа боодлыг сайтар шалгаж, нар, салхинд элэгдэх элэгдлийг тооцох
- Химийн бүтээгдэхүүн, бодисыг ашиглах, хадгалах явцад хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх, химийн бодис хадгалах, ашиглах болон тээвэрлэх үед савны битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг байнга шалгах.
- Бүх төрлийн химийн бодис, ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол, нарны шууд гэрэл тусахааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд хадгалах
- Химийн бүтээгдэхүүн, бодис хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, Агаарын чанарыг хянах, шинжлэх
- Химийн бодис, бүтээгдэхүүнийг хэрэгцээнээс илүү хэмжээгээр нөөцлөн нийлүүлэхгүй байх,
- Химийн бодис алдагдсан тохиолдолд хоргүйжүүлэх, саармагжуулах үйл ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулах байнгын бэлтгэлтэй байх
- Химийн бодисын ослын үед ажиллах төлөвлөгөөг тодотгох
- Галын аюулгүй байдлын дүрэм мөрдөж ажиллах.
- Тусгай хөтөлбөрийн дагуу химийн бүтээгдэхүүн, бодистой харьцаж ажилладаг хүмүүсийг сургалтыг зохион байгуулах, мэргэшүүлэх, чадавхыг дээшлүүлэх, шинээр ажилд орсон хүмүүсийг ажилд орохын өмнө сургалтад хамруулж, шалгалт авах



Технологийн химийн бодиснуудын зөвшөөрлүүдийг холбогдох төрийн захиргааны байгууллагуудаас бүрэн авч ажиллаж байна. /тусгай зөвшөөрлүүдийг хавсралтаар оруулав/

"Эрдмин" ХХК нь Гаалийн ерөнхий газрын даргын 2011 оны 471 дүгээр тушаалаар химийн бодис хадгалах зориулалтаар Гаалийн түр агуулахын зөвшөөрлийг авсан байна.



Тус үйлдвэрийн хүхрийн хүчил буулгах, хадгалах зориулалтын гаалийн түр агуулахаар 4,5-р сав зарлагдсан байдаг.

Хэмжээ -100,55 куб.метр

Хүчин чадал- 184тонн



Хүхрийн хүчлэг өөрийн үйлдвэрийн технологид нэмэх хүртэл шахах зориулалттай АНУ-д үйлдвэрлэгдсэн 380в хүчдэлд ажилладаг, 50гц давтамж бүхий 22кВт, 15кВт чадалтай 2ш насос суурилуулан ашиглаж байна.

Хүхрийн хүчлийн агуулах нь 24 цагийн хяналт, харуул хамгаалалтанд байхаас гадна, Эрдмин үйлдвэрийн дотоод сүлжээнд холбогдсон HIK VISION -4200 маркын хяналтын камер, Гаалийн газрын сүлжээнд холбогдсон DANUA DH-IPC-HFW1431S, 4MP WDR IR MINI-BULLET маркын хяналтын камераар тоноглогдсон байдаг.

2025 онд эрсдэлээс урдчилан сэргийлэх зорилгоор хүхрийн хүчил хадгалах 92тн багтаамжтай 4 ширхэг ёмкосьтыг шинээр солив.



Ингэснээр хүхрийн хүчил хадгалах савны аюулгүй найдвартай байдлыг сайжруулсан ажил болсон байна.

Технологийн лаборторт хэрэглэгдэх химийн бодис хадгалах агуулах нь “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014” стандартын шаардлагыг хангадаг.



Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын дагуу 28 төрлийн бодисыг хадгалж ашиглаж байна.

Химийн бодисын задгай агуулахыг тойруулан MNS 6458 : 2014 стандартын 5.8.1-д заасны дагуу 2м өндөртэй бетонон хашаа барьж хяналтын камер суурилуулав.



НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- Үйлдвэрийн ахуйн хог хаягдлыг аймгийн төвлөрсөн цэгт зөөвөрлөн хаях
- Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж дахин боловсруулалтад шилжүүлэх
- Химийн лабораторын ашиглагдахгүй болсон бодисуудыг холбогдох журмын дагуу хадгалах, тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар устгуулах
- Эмнэлгийн хог хаягдлыг эрх бүхий байгууллагаар зориулалтын цэгт устгуулах
- Автомашинд хэрэглэсэн тосолгооны бодисыг дахин боловсруулах тусгай зөвшөөрөлтэй ААН –д шилжүүлэх
- Химийн бодисын хуримтлагдсан хуванцар савнууд устгалд өгөх

Орхон аймгийн хот тохижуулах газартай байгуулсан гэрээний дагуу аймгийн төвлөрсөн хогын цэгт ахуйн хог хаягдлыг хаяж байна. Тайлант онд 90м3 хог хаясан байна.



Ахуйн хог хаягдлаас хуванцар сав болон шилэн хаягдлыг ангилан хаясан.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хог хаягдлыг журмын дагуу дотооддоо түр хугацаанд хадгалсаны дараа тусгай зөвшөөрөл бүхий газарт хаяж устгуулж байна.





Химийн бодисын сав баглаа боодол 79кг, химийн бодист бохирдсон хувцас хамгаалах хэрэгсэл 117кг -ийг, ИВС танк 3ш -ийг төмөр чингэлэгт түр хадгалж байна. Түр хугацаанд хуримтлуулж буй шалтгаан нь устгал хийх тусгай зөвшөөрөл бүхий гэрээт байгууллагын тээврийн хэрэгслэлийн ачааг дүүргэх зорилготой.



Үйлдвэрийн автомашин техник хэрэгслүүдийн ашигласан моторын тос, хөргөлтийн шингэн зэрэг аюултай хог хаягдлуудыг мөн тусгай агуулахад түр хадгалж, хуримтлуулж байна.

2025 оны хувьд автомашины ажилласан тос масло 1,800л -ийг мөн төмөр торхонд хадгалж байна.

Үйлдвэрийн цахилгаан химийн цехэд ашигладаг хар тугалган шинийн элэгдлээс үүссэн хар тугалганы шлам 2023кг-ыг тусгай зөвшөөрөл бүхий “Үлэмж хүдэр” ХХК-д гэрээний дагуу шилжүүлсэн байна.



**ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ**


- Ус ашиглах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээг байгуулах, гүйцэтгэлийг хангах
- Байгууллага нь ажилчдын үүрэгт ажил болон байгууллагын түвшинд байгаль орчны зорилго, зорилтыг танилцуулах, Байгаль орчны сургалт семинарыг зохион байгуулж, түүнд хамруулах
- Байгаль орчны суурь нөхцөлд өөрчлөлт гарсан эсэхэд хяналт тавьж, хэмжилт хийх
- Байгаль орчны судалгаа үнэлгээ, хяналттай холбоотой бүртгэлийн хяналт хэрэгжүүлэх

2025 онд Эрдмин үйлдвэр үйл ажиллагаандаа 34,700 шоо метр ус ашиглахаар Сэлэнгэ голын сав газрын захиргаанаас дүгнэлт гаргуулж, Булган аймгийн Байгаль орчны газраас ус ашиглах зөвшөөрөл авч ажиллаж байна.



“Эрдмин” ХХК-ийн Зэс ялгах үйлдвэр нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ус хангамжийн цехийн төвлөрсөн ус хангамжийн ахуйн усны $\text{d}\varnothing 200\text{мм}$ -ийн шугмын ВК-45 дугаар худгаас $\text{d}\varnothing 100\text{мм}$ -ийн шугмаар, Зэс утасны үйлдвэр нь промбазын туннелийн $\text{d}\varnothing 200\text{мм}$ -ийн шугмаас $\text{d}\varnothing 50\text{мм}$ -ийн хоолойгоор хангагдана. Мөн бохир усны дүгнэлтийг Орхон чулуутын сав газрын захиргаагаар гаргуулж Орхон аймгийн Баян-Өндөр сумаас 3,000 шоо метр бохир ус хаях зөвшөөрөл авч ажиллаж байна.

Тайланд онд ашигласан усны хэмжээ 10-р сарын байдлаар 8,752м³ ус хэрэглэсэн, үүнээс үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд 6,903м³ ус ашигласан байна. Тайланд онд усны хэрэглээ бага байгаа шалтгаан нь зун намрын улиралд хур тунадас ихтэй, сэрүүн уур амьсгалтай байсан, мөн 2024 онд үйлдвэрийн уусмалын баланс аваарийн байдалтай буюу нийт цөөрмүүдийн хэмжээ байвал зохих хэмжээнээс 50%-аас өндөр байсан нь нөлөөлсөн.



Компанийн хэмжээнд байгаль орчны удирдлага зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандарт ISO 14001:2015 -ийг нэвтрүүлээд 3 жил болж байна.

Энэ хугацаанд Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандартын шаардлагын хүрээнд хөндлөнгийн болон дотоод аудитыг зохион байгуулж, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна.

АРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

- Орхон аймгийн Баянцагаан багийн иргэдэд тайлагнах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянах, үнэлгээ өгөх ажлын хэсгийн гишүүдэд тайлагнах

Орхон аймгийн Баянцагаан багийн иргэдийн нийтийн хуралд тайлан танилцуулга хийх хүсэлт тавьсаны дагуу тус багийн Иргэний танхимд зохион байгуулав.



Багийн иргэдэд үйлдвэрийн үйл ажиллагааг нээлттэй дэлгэрэнгүй танилцуулж, 2025 онд байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлуудаа тайлагнаж ажиллав.



Орхон аймгийн засаг даргын захирамжаар байгуулагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт хянах ажлын хэсэг Эрдмин үйлдвэрийн гүйцэтгэлийн тайланг сонсож, гүйцэтгэсэн ажлуудтай газар дээр нь танилцаж дүгнэлт гаргав.

АРВАН НЭГ. ДҮГНЭЛТ
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ -100%

№	Зорилт	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэсэн байдал
1.	Балансын бус хүдрийн овоолгын талбай, дотоод тээврийн зам, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэхээс сэргийлэх	Машин техникийн хурдыг багасгах, зөвшөөрсөн замаар хөдөлгөөнд оролцох, тэмдэг тэмдэглэгээг хатуу мөрддүүлэх, талбайруу явах замуудыг услаж тоосжилтыг дарах тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэгт оруулж, ялгаруулж буй хорт хийн түвшинд хяналт тавих, засвар үйлчилгээг тогтмол хийх.	Үйлдвэрийн бүсэд хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн жолооч нарт “ ҮЙЛДВЭРИЙН БҮСЭД ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ЖУРАМ”-ийг танилцуулж давтан зааварчилгаа өгч хянаж ажиллаж байна. Үйлдвэрийн 17 ширхэг автомашин, механизмуудыг техникийн улсын үзлэгт оруулж ялгаруулж буй хорт хийг хянаж байна. Мөн хугацаат засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэж байна.
2.	Химийн бодисын агуулахад химийн бодистой харьцан ажиллах үед агуулахын шал, гадаад орчинд асгарсанаас ажлын байрны агаар орчинд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх	Химийн бодисыг шатах, гал авалцах эх үүсвэр болон хамт хадгалж болохгүй бодисуудыг тусад нь хадгалах	“ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС АЮУЛГҮЙ АШИГЛАХ ДҮРЭМ”-ийн дагуу хамт хадгалж болохгүй бодис, урвалжуудыг тусд нь хадгалж химийн бодисын агуулахын стандартыг хангуулан ажиллаж байна.
3.	Уусмал алдаж гүний ус бохирдуулахаас сэргийлэх	Уусмал хуримтлуулах цөөрмүүдийг тогтмол хянах.	Уусмал хуримтлуулах цөөрмүүдийг тогтмол хянаж ажиллаж байна. Үүний дүнд 1-р цөөрмийн полиэтелин бүрээсийг бүрэн сольж шинэчилсэн.

4.	Овоолгийн хэсгээс байгалийн ус буюу хур борооны хуримтлагдсан шүүрлийн ус Хангал голд урсан орохоос сэргийлж ажиллах	"Эрдэнэт үйлдвэр"ТӨҮГ-ийн байгуулсан даланд борооны ус дүүрсэн тохиолдолд 2 инчийн HDPE хоолой, адаптар хавхлаг, насос ашиглаж усыг ил уурхайруу татах	Овоолгоор дамжих борооны шүүрлийн усыг 400м ³ -ийн багтаажтай хуримтлуулах саванд цуглуулж "Эрдэнэт үйлдвэр"ТӨҮГ-ийн 5000м ³ -ын эзлэхүүнтэй цөөрөмрүү татан авах 2 инчийн HDPE труба суурилуулж ашиглаж байна. .
----	--	--	---

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ-100%

№	Зорилт	Нөхөн сэргээлтийн талаар хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэсэн байдал
1.	Гэнэтийн нөхцөл болон хаалтад бэлтгэх шаардлагатай эрсдэлийн сан үүсгэх	Захирлуудын зөвлөлийн шийдвэрийн дагуу нөхөн сэргээлтийн дансанд 5сая төгрөг шилжүүлэн байршуулах	Захирлуудын зөвлөлийн шийдвэрийн дагуу нөхөн сэргээлтийн дансанд 5сая төгрөг шилжүүлэн байршуулсан.
2.	Эдэлбэр газрыг тогтмол ургамалжуулж газрын гадарга элэгдэхээс сэргийлэх	Үйлдвэрийн хашаан доторх газрын ургамалжуулах арга хэмжээг үргэлжлүүлэн жил бүр хэрэгжүүлэх	Тайлант онд үйлдвэрийг хүдрийн овоолгийн хэсгээс шинээр ургаж гарч ирсэн зулзган модноос шилжүүлэн мод үржүүлгийн талбайд тарив.

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ -100%

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Гүйцэтгэсэн байдал
1.	Сум орон нутгийн хүсэлтээр эхийг сэргээн хашиж тохижуулсан булгийг үргэлжлүүлэн хамгаалах	Хүрэн булгийн рашааны хамгаалалтыг сэргээн засварлах	Хүрэн булгийн рашааны хамгаалалтын хашааг засварлах болон зарим хэсгээр дээш гарсан шовх үзүүрүүдийг дарж өндөрлөгөө хийв.

2.	Бүс нутгийн цөлжилтөөс сэргийлэх Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Өмнө жилүүдэд тарьсан моднуудын ургалт, хамгаалалтанд анхаарах, нөхөн тарилт хийх	Ойн санд хүлээлгэн өгөөгүй байгаа 2022 оноос хойш тарьсан 4410 ширхэг шинэс, улиас, чацаргана, хус, хайлаас зэрэг моднуудын хамгаалалт, арчилгааг тогтмол хийж байна. Мөн 100 орчим модны нөхөн тарилт хийв.
3.	Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, бүх нийтээрээ мод тарих өдрүүдээр 1 га газарт хүртэлх талбайд мод бут сөөг тарьж арчлан биологийн нөхөн сэргээлт хийх	Мод тарьж арчлан хамгаалах	Орхон аймгийн Байгаль орчны газраас зааж өгсөн цэгт 1,28га талбайд 1500 ширхэг бургас, улиас мод тарив.
4.	Эзэнгүй дүүргийн хог хаягдлыг цэвэрлэх	Аймгийн байгаль орчны газраас зохион байгуулах хог цэвэрлэгээний ажилд хариуцуулах талбайн цэвэрлэгээг хийх	Орхон аймгийн Байгаль орчны газартай хамтран Чингэлийн голын голдирол дагуу цэвэрлэгээ хийж 5м ³ хог хаягдал аймгийн төвлөрсөн хогын цэгт хаяв.
5.	Орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж тохирсон газарт ойжуулах, хөрс хамгаалах, цөлжилтийг бууруулах арга хэмжээ авах.	Мод үржүүлгийн газрыг бүрэн чадлаар нь ажиллуулах, үр үрсэлгээний тоог нэмэгдүүлэх.	Мод үржүүлгийн газарт шинэс, гүйлс, буйлс, улиас, бургас зэрэг мод тарьж ургуулж байна. Энэхүү мод үржүүлгийн газраас гарсан тарьцаар Орхон аймгийн ойн сан нэмэгдүүлэх чиглэлд ажил зохион байгуулах зорилготой.

ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ -100%

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Гүйцэтгэсэн байдал
1.	Уусмал хуримтлуулах цөөрмүүдийн хамгаалалтын HDPE доторлогоо элэгдэж микро нүх сүв үүссэний улмаас зэс болон бусад төрлийн хортой металл агуулсан хүхрийн хүчлийн уусмал хөрс, грунт рүү нэвчиж, гүний усыг бохирдуулах, бохирдлын эх үүсвэр бий болгохоос сэргийлэх	Цөөрмүүдийн HDPE доторлогоонд нүх сүв үүссэн эсэхийг хянах багаж төхөөрөмжтэй байх, тогтмол хугацаанд хянах, үр дүнг баримтжуулах	Уусмал хуримтлуулах цөөрмүүдийг тогтмол хянаж ажиллаж байна. Үүний дүнд 1-р цөөрмийн полиэтелин бүрээсийг бүрэн сольж шинэчилсэн.
2.	Химийн бүтээгдэхүүн, түлш шатахуун асгарч алдагдсанаас орчны агаар бохирдох	Керосины агуулахын байрыг тойруулан хашаа барих, шал хамгаалалтыг шалгаж шаардлагатай бол засварлаж байх	Керосины агуулахыг тойруулан Химийн бодисын задгай агуулахыг тойруулан MNS 6458 : 2014 стандартын 5.8.1-д заасны дагуу 2м өндөртэй бетон хашаа барьж хяналтын камер суурилуулав.
3.	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах химийн бодис, бүтээгдэхүүн хөрсөнд алдагдаж асгарснаас ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлөх	Химийн бодис алдагдсан тохиолдолд хоргүйжүүлэх, саармагжуулах үйл ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулах байнгын бэлтгэлтэй байх	Химийн ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулан Орхон аймгийн онцгой байдлын газартай хамтран ажиллаж, дадлага сургуулилтыг мөн хийж байна.

ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ -100%

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэсэн байдал
1.	Ахуйн хог хаягдлын менежмент	Гэрээний дагуу хог хаягдал хотын төвлөрсөн цэгт хаях	Ахуйн хог хаягдлыг Орхон аймгийн Хот тохижуулах газартай гэрээ байгуулан хогны төвлөрсөн цэгт зөөвөрлөж хаяж байна. Мөн ахуйн хогноос ус ундаа, артишикны шил, хуванцар сав зэргийг ангилан ялгаж хаяж байна.
2		Ахуйн хог хаягдлыг агилан ялгаж хаях	
3	Аюултай хог хаягдал	Эмнэлгийн хог хаягдлыг устгуулах	Тайлант хугацаанд үйлдвэрийн үйл явцаас үүсч гарсан 2023кг хар тугалганы шламыг “Үлэмж хүдэр”ХХК-д шилжүүлсэн. Химийн бодисын сав баглаа боодол, химийн бодист бохирдсон хувцас хамгаалах хэрэгсэл зэргийг хуримтлуулан журмын дагуу хадгалж байна.
4		Химийн бодисын сав баглаа боодол устгуулах	
5		Химийн бодист бохирдсон хамгаалах хэрэгслүүд устгуулах	
6		Ажилласан тос масло хуримтлуулж устгуулах, тээврийн зардал	

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР -100%

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Давтамжийн тоо	Гүйцэтгэсэн байдал
1.	Уусмал алдах болзошгүй эрсдэлээс сэргийлж тогтмол хянаж ажиллах	Гүний усны хяналтын 7 цэгээс сар бүр дээж авч шинжлүүлэх	12	Орчны хяналт шинжилгээг Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газартай гэрээ байгуулж сар бүр хамтран дээж авч шинжлэн хянаж байна. Тус шинжилгээний дүнгүүдийг Байгаль орчны хяналтын улсын байцаагчаар хянуулан ажиллаж байна. Мөн “Эрдэнэт үйлдвэр”ТӨҮГ-ийн байгаль орчны хяналт лабораторитой хамтран хянаж байна.
2.	Уусгалт, уусган хандлалт, электролизийн үйл ажиллагаанаас хүхрийн хүчил хөрсөн	Хөрсний мониторингийн 4 цэгүүдэд ерөнхий химийн шинжилгээ жилд 2 удаа хийлгэх	4	
3.	бүрхэвчид алдагдах нөлөөлөх	Хөрсөнд хүнд металлын шинжилгээг 2цэгээс 1 удаа хийлгэх	2	
4.	Агаарын чанарын шинжилгээ судалгааг тогтмол хийлгэж үр дүнгээр эрсдэлийг хянах	УЦУОШ-тай гэрээ байгуулан 4 цэгээс 4удаагын давтамжтай агаарын шинжилгээ хийлгэх	6	
5	Агаарын чанарын стандарттай харьцуулан судалж сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авах	Үйлдвэрийн барилга доторх агаарын шинжилгээ хийлгэх	12	
5.	Агаарын чанарын стандарттай харьцуулан судалж сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авах	Үйлдвэрийн барилга доторх агаарын шинжилгээ хийлгэх	12	

**ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ -100%**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Гүйцэтгэл
1.	Ус ашиглалтын тухай хуулийн хэрэгжилт хангах, дүгнэлт зөвшөөрлүүд гаргуулах	Сэлэнгэ голын сав газрын захиргаанаас 34700 шоо метр ус ашиглах дүгнэлт гаргуулсан ба Цэвэр ус ашиглах зөвшөөрлийг Булган аймгийн Байгаль орчны газраас, бохир ус татан зайлуулах зөвшөөрлийг Орхон аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-аас, Бохир усны дүгнэлтийг Орхон чулуутын сав газрын захиргаанаас гаргуулан ажиллаж байна.
2.	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр дотоод аудит гүйцэтгэх, дүгнэлтийг ерөнхий захиралд танилцуулах	Эрдмин ХХК-ийн Байгаль орчны хөндлөнгийн аудитыг “Ногоон гэрэлт ирээдүй” ХХК-аар гүйцэтгүүлэв. Дотоод аудит 1 удаа зохион хийгдэв.
3.	Орхон аймгийн засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлыг танилцуулж дүгнэлт гаргуулах	Орхон аймгийн засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2025 оны 11-р сард үйлдвэрийн үйл ажиллагаа болон тайлант оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянаж 96 оноогоор дүгнэсэн байна.

ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-ИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ -100%

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Гүйцэтгэл
1.	Баянцагаан багын иргэдэд төслийн үйл ажиллагааг нээлттэй Танилцуулах	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан багын нутаг дэвсгэрт Эрдмин компани үйл ажиллагаагаа явуулдаг тул тус багын иргэдийг үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцуулах болон иргэний танхимд оршин суугчдын төлөөлөлд 2025 оны БОМТ-ийн биелэлт болон нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудаа танилцуулж ажиллав.

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн төсөв

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
4.1	1. Тайлант жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэхэд зарцуулсан зардал	50'375'960 ₮
	2. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд	Үйлдвэрлэлийн зардалаар гүйцэтгэсэн
	4. Нөхөн сэргээх арга хэмжээнд /техникийн, биологийн/	1'277'501 ₮
	5. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээнд	31'306'340 ₮
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах ажлын зардал	120'000 ₮
	7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний зардал	15'150'000 ₮
	8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээнд	0₮
	9. Хог, хаягдлын менежментийг хэрэгжүүлэх арга хэмжээнд	1'493'121 ₮
	10. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардал	2'029'000 ₮

АРВАН ХОЁР. ХАВСРАЛТУУД

Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ,
ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ,
АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2022-11-14

Дугаар: 0002290

Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: ЭРДМИН ГХО ХХК

Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9019007004

Регистрийн дугаар: 2073358

Хаяг: Орхон, Жаргалант, 2-р баг, Жаргалант, 00

Утас: 72175, 99351215

Дараах химийн хортой, аюултай бодис:

Импортолох, ашиглах

аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай

зөвшөөрлийг

2022.11.14-2026.12.31

хүртэл хугацаагаар олгов.

№	Бодисын нэр		Томьёо	Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/	Ангилал	Үйлдвэрлэсэн улс	Хэмжээ
	Монгол	Олон улсын					
1	Кобальтын сульфат	Cobalt sulfate heptahydrate	CoSO ₄ * 7H ₂ O	10124-43-3			2 тн
2	Хүхрийн хүчил	Sulfuric acid	H ₂ SO ₄	7664-93-9			3000 тн
3							
4							
5							
6							
7							
8							

Улсын хилээр нэвтрүүлэх боомт: Замын-Үүд, Алтанбулаг, Сүхбаатар, Чингис хаан

Зөвшөөрөл олгосон: Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Төрийн нарийн бичгийн дарга

Э. БАТТУЛГА /

Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Ц.БАТЖАРГАЛ /



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024.08.15

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл

Регистрийн дугаар : 2073358

Нэр : ЭРДМИН ХХК /ГХО/



Зөвшөөрөлтэй холбосотой мэдээлэл

Авсан огноо : 2021-08-02

Дуусах огноо : 2027-08-15

Хүчинтэй эсэх : Хүчинтэй

Тусгай зөвшөөрлийн нэр : БҮХ ТӨРЛИЙН ШАТАХУУН ИМПОРТЛОХ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татан авч байнгын шалгуур болгон ашиглаж байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгууруудыг хангасан эсэхээс хамааран гэрчлэгээний төлөв өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ,
ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ,
АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2022-08-30

Дугаар: 0002239

Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: ЭРДМИН ГХО ХХК

Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9019007004

Регистрийн дугаар: 2073358

Хаяг: Орхон, Жаргалант, 2-р баг, Жаргалант, 00

Утас: 72175, 99351215

Дараах химийн хортой, аюултай бодис:
Ашиглах

аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай
хүртгэл хугацаагаар олгов.

зөвшөөрлийг 2022.08.30-2026.12.31

№	Бодисын нэр		Томьёо	Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/	Ангилал	Үйлдвэрлэсэн улс	Хэмжээ
	Монгол	Олон улсын					
1	Хавсралтад дурдсан 28 нэр төрөл бодис						
2							
3							
4							
5							
6							
7							
8							

Улсын хилээр нэвтрүүлэх боомт: -----

Зөвшөөрөл олгосон: Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Төрийн нарийн бичгийн дарга

Э. БАТТУЛГА /

Химийн хорт болон аюултай бодисын бодлого
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Ц.БАТЖАРГАЛ /

Химийн хорт болон аюултай бодисыг
Ашиглах 0002239 дугаартай
тусгай зөвшөөрлийн хавсралт

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Томъёо	CAS дугаар	Зөвшөөрсөн хэмжээ, кг
1	Кали иод	Potassium iodide	KI	7681-11-0	180
2	Давсны хүчил	Hydrochloric acid	HCl	7647-01-0	20
3	Цууны хүчил	Acetic acid	CH ₃ COOH	64-19-7	70
4	Аммиак	Ammonium	NH ₃	7664-41-7	20
5	Фосфат натри	Trisodium phosphate	Na ₃ PO ₄ *12H ₂ O	7601-54-9	20
6	Фосфорын хүчил	Phosphoric acid	H ₃ PO ₄	7664-38-2	2
7	Ацетон	Acetone	CH ₃ COCH ₃	67-64-1	15
8	Натрийн карбонат	Sodium carbonate	Na ₂ CO ₃	497-19-8	15
9	Натрийн шүлт	Sodium hydroxide	NaOH	1310-73-2	5
10	0.1н идэмхий натри /фиксиналь/	Sodium hydroxide	NaOH	1310-73-2	2
11	Сульфат аммони	Ammonium sulfate	(NH ₄) ₂ SO ₄	7783-20-2	25
12	Натрийн бикарбонат	Sodium bicarbonate	NaHCO ₃	144-55-8	20
13	Этилийн спирт	Ethanol	C ₂ H ₅ OH	64-17-5	8
14	Калийн оксалат	Oxalic acid, dipotassium salt	K ₂ C ₂ O ₄ *H ₂ O	583-52-8	70
15	Азотын хүчил	Nitric acid	HNO ₃	7697-37-2	1.4
16	Зэсийн байван	Copper(II) sulfate pentahydrate	CuSO ₄ *5H ₂ O	7758-99-8	1
17	Ацетат натри	Sodium acetate trihydrate	CH ₃ COONa*3 H ₂ O	127-09-3	1
18	Тиосульфат натри	Sodium thiosulfate pentahydrate	Na ₂ S ₂ O ₃ *5H ₂ O	7772-98-7	15
19	0.1н хүхрийн хүчлийн фиксиналь	Sulfuric acid	H ₂ SO ₄	7664-93-9	1.5
20	Хүхрийн хүчил	Sulfuric acid	H ₂ SO ₄	7664-93-9	3.5
21	Фторт аммони	Ammonium hydrogen fluoride	NH ₄ F	12125-01-8	15
22	Цардуул	Amylodextrin	(C ₆ H ₁₀ O ₅) _n	9005-84-9	0.5
23	Бихромат кали 0.25N фиксиналь	dichromic acid	K ₂ Cr ₂ O ₆	7778-50-9	0.5
24	Буфер уусмал pH=6.86	Buffer solution			10
25	Буферуусмал pH=4.00	Buffer solution			10
26	Буферуусмал pH=2.00	Buffer solution			10
27	Зэсийнс тандарт 1000ppm	Copper	Cu		1
28	Зэс уусган баяжуулагч	LIX 984N	-	84852-15-3	12 тн

Handwritten signature and official stamp of the Ministry of Health of Mongolia.

Химийн бодисын агуулахын нөхцөлд гаргасан МХГ-н дүгнэлт



“ЭРДМИН” ХХК-д

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

61000 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Залуучуудын
гудамж-1, Захиргааны III байр, 3 давхарт
Утас/Факс: 70359050
E-mail: p_or@inspection.gov.mn

2015.02.02 № 14-06-024/1

Химийн бодисын агуулахын нөхцөлд дүгнэлт гаргах тухай

Тус компани нь Орхон аймгийн Баян-өндөр сум Баянцагаан баг өөрийн үйлдвэрлэлийн байрандаа байрладаг химийн бодис хадгалах агуулахдаа ажлын байрны дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн дагуу урьдчилсан хяналтыг 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр холбогдох хүмүүсийг байлцуулан хийлээ.

Дээрх агуулахуудыг 1997 оноос химийн бодис хадгалах зориулалтаар барьж ашиглаж байгаа бөгөөд нийт 3 төрлийн, Үүнд:

1.Лабораторийн химийн бодисын агуулах-19 нэр төрлийн химийн бодис хадгалах хүчин чадалтай, инженерийн шугам сүлжээнд холбогдсон, зориулалтын агааржуулалтын системтэй, нийт 28м² талбайтай.

2.Технологийн химийн бодисын агуулах-үйлдвэрлэлийн технологийн процесст нэмэх 4 төрлийн химийн бодис хадгалдаг, зориулалтын агааржуулалтын системэй, химийн бодис асгарсан тохиолдолд хөрсөнд нэвтрэхээс хамгаалсан цементэн шалтай, нийт 196м² талбайтай.

3.Хүхрийн хүчлийн агуулах: Хүхрийн хүчил хадгалах зориулалттай гаалийн түр агуулах, нийт 780м² талбайтай, тус бүрдээ 92тн /50.4м³/ багтаамжтай 6 ёмкосттой, түүний доор хүчил асгарах, халих болзошгүй аюулын үед суллах зориулалттай 400тн /200м³-н полиэтилен доторлогоотой баннтай.

Тус агуулахуудын ажлын байрны орчинд физик хэмжилт хийхэд байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, агаарын температур, харьцангуй чийглэг эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан, энгийн болон механик агааржуулалтын систем суурилуулсан нь MNS 6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг хангаж байна гэж дүгнэв.

Хувь:2

БАЙГАЛЬ ОРЧИН ГЕОЛОГИ, УУЛ УУЛРХАЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ *Р.Г.О.О.* Д.СҮХБАТ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ *Г.Б.АТЦЭЦЭГ* Г.БАТЦЭЦЭГ





Монгол Улсын Шадар сайдын 2023 оны
11 дүгээр сарын 10-ны өдрийн 75 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

